



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.12.2, 14.12.3 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтын 1-т заасан хуулийн этгээдийн “Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 2-т заасан хуулийн этгээдийн “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 3-аас 6-д заасан хуулийн этгээдүүдийн “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл, 7-оос 9-т заасан хуулийн этгээдүүдийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаатай тус тус түдгэлзүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШУУД

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

М.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
226 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацааг 90 хоногоор түдгэлзүүлсэн
хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Ёл цуурай ХХК	13000035	2028-12-28	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх
2	Гангын урсгал ХХК	12900348	2028-06-30	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх
3	Модерн Кастл Модифаер ХХК	12900039	2028-12-06	Монгол улсын нутаг дэвсгэрт Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх
4	Багануур хөгжлийн зам НҮТББ	12800121	2027-06-27	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх
5	Одтой цэг ХХК	12800211	2028-06-19	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх
6	Одтой цэг ХХК	12800208	2028-06-30	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх
7	Багануур хөгжлийн зам НҮТББ	22800131	2027-06-27	Улаанбаатар хотын Багануур дүүргийн нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах
8	Одтой цэг ХХК	22800215	2028-06-30	Дархан уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах
9	Одтой цэг ХХК	22800218	2028-06-19	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах

----- оОо -----